



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/94/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... | 3 |
| Асуудлыг онцолсон хэсэг..... | 3 |
| Аудитын гол асуудал..... | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 13 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 16 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 18 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... | 19 |
| 5.1 Төлбөрийн акт..... | 19 |
| 5.2 Албан шаардлага..... | 19 |
| 5.3 Зөвлөмж..... | 19 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН 29 дүгээр
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.САРАНГЭРЭЛ ТАНАА

2025, 02.25 № 96

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,408.8 мянган төгрөгийн компьютер, 12,771.4 мянган төгрөгийн угаалгын машин, 5,742.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 540,930.9 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 50.9 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 99 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 125,371,560.45 | 200,578,410.34 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 97,891,648.51 | 165,663,541.99 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 97,891,648.51 | 165,663,541.99 |
| 33 | АВЛАГА | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 27,479,911.94 | 34,914,868.35 |
| 351 | Түүхий эд материал | 160,000.00 | - |
| 3513 | Эм боох материал | 160,000.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 27,319,911.94 | 34,914,868.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,237,000.00 | 3,793,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,813,220.00 | 12,361,630.00 |
| 3546 | Хүнсний материал | 4,680,281.94 | 5,649,828.35 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,589,410.00 | 13,110,410.00 |
| 36 | НӨӨЦ БАРАА | | |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,405,245,651.31 | 1,399,562,205.07 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,405,245,651.31 | 1,399,562,205.07 |
| 392 | Биет хөрөнгө | 1,289,369,318.11 | 1,282,596,205.07 |
| 39201 | Барилга, байгууламж орон сууц | 1,363,999,924.00 | 1,363,999,924.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (125,843,329.45) | (162,704,099.65) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,269,698.65 | 69,769,581.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12,194,698.85) | (17,188,007.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,517,936.65 | 49,050,192.51 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,451,031.80) | (22,115,315.78) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,386,390.00 | 2,386,390.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (611,271.09) | (898,160.13) |
| 39217 | Ном | 295,700.00 | 295,700.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 115,876,333.20 | 116,966,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,250,000.00 | 1,320,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,041,666.80) | (22,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 115,668,000.00 | 115,668,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,530,617,211.76 | 1,600,140,615.41 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,530,617,211.76 | 1,600,140,615.41 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,530,617,211.76 | 1,600,140,615.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 115,668,000.00 | 115,668,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | - | - |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,414,949,211.76 | 1,484,472,615.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,414,949,211.76 | 1,414,949,211.76 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 69,523,403.65 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,530,617,211.76 | 1,600,140,615.41 |



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 588,200,000.00 | 850,829,668.36 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,000.00 | 41,582,168.36 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 35,000.00 | 41,582,168.36 |
| 120042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 40,262,168.36 |
| 120045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 1,320,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 588,165,000.00 | 809,247,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 564,665,000.00 | 779,247,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 23,500,000.00 | 30,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,500,000.00 | 30,000,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 550,583,304.52 | 781,306,264.71 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 550,583,304.52 | 781,306,264.71 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 546,774,035.56 | 780,297,284.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,414,026.97 | 540,930,903.95 |
| 210101 | Үндсэн цалин | 264,867,468.86 | 382,695,493.43 |
| 210102 | Нэмэгдэл | 81,829,388.81 | 143,826,700.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 11,717,169.30 | 14,408,710.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 45,871,202.74 | 68,135,799.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,810,580.86 | 46,551,228.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,722,457.44 | 5,725,017.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,887,566.02 | 2,885,757.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 674,054.32 | 2,594,758.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,776,544.10 | 10,379,036.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,864,431.04 | 20,493,370.11 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,997,302.26 | 6,175,228.11 |
| 210302 | Түлш, халаалт | 6,281,254.94 | 6,291,466.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,585,873.84 | 8,026,675.72 |
| 210304 | байрны түрээс | - | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,157,460.00 | 9,164,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,870,940.00 | 7,257,210.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,286,520.00 | 1,907,090.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 60,785,944.09 | 77,287,726.59 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 125,400.00 | 938,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | 60,660,544.09 | 76,349,376.59 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,300,000.00 | 8,527,650.00 |
| 210601 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,300,000.00 | 8,527,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 640,400.00 | 2,245,000.00 |
| 210806 | мэдээлэл, технологийн үйлчилгээ | 640,400.00 | 2,245,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,740,570.72 | 53,512,534.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,406,340.12 | 5,476,950.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,334,230.60 | 48,035,584.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,809,268.96 | 1,008,979.89 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,473,700.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,473,700.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 335,568.96 | 1,008,979.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 335,568.96 | 1,008,979.89 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 0.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 0.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 37,616,695.48 | 69,523,403.65 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 37,616,695.48 | 69,523,403.65 |




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 588,200,000.00 | 809,247,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,000.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 35,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 588,165,000.00 | 809,247,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 564,665,000.00 | 779,247,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 564,665,000.00 | 779,247,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 23,500,000.00 | 30,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,500,000.00 | 30,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 508,020,276.83 | 740,705,636.52 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 508,020,276.83 | 740,705,636.52 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 504,211,007.87 | 739,696,656.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 358,414,026.97 | 540,930,903.95 |
| 210101 | Үндсэн цалин | 264,867,468.86 | 382,695,493.43 |
| 210102 | Нэмэгдэл | 81,829,388.81 | 143,826,700.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 11,717,169.30 | 14,408,710.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| 2102 | Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 45,871,202.74 | 68,135,799.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 31,810,580.86 | 46,551,228.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 3,722,457.44 | 5,725,017.01 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,887,566.02 | 2,885,757.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 674,054.32 | 2,594,758.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 6,776,544.10 | 10,379,036.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,864,431.04 | 20,493,370.11 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,997,302.26 | 6,175,228.11 |
| 210302 | Түлш, халаалт | 6,281,254.94 | 6,291,466.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,585,873.84 | 8,026,675.72 |
| 2105 | Нормативт зардал | 60,889,977.00 | 77,318,923.00 |
| 210502 | Хоол, хүнс | 60,889,977.00 | 77,318,923.00 |
| 2106 | Эд хогшил урсгал засвар | 1,300,000.00 | 8,497,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,300,000.00 | 8,497,650.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж | 683,300.00 | 2,245,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 683,300.00 | 2,245,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,188,070.12 | 22,075,010.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,419,280.12 | 13,977,560.12 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,768,790.00 | 8,097,450.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,809,268.96 | 1,008,979.89 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,473,700.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 3,473,700.00 | - |

| | | | |
|--------|--|----------------|----------------|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг | - | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 335,568.96 | 1,008,979.89 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 335,568.96 | 1,008,979.89 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 80,179,723.17 | 68,541,863.48 |
| | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | | |
| | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн | 2,217,000.00 | 769,970.00 |
| 6 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (2,217,000.00) | (769,970.00) |
| 8 | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 77,962,723.17 | 67,771,893.48 |
| 9 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 19,928,925.34 | 97,891,648.51 |
| 10 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 97,891,648.51 | 165,663,541.99 |



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| C01 | 2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 115,668,000.00 | | 1,377,332,516.28 | - | 1,493,000,516.28 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 115,668,000.00 | - | 1,377,332,516.28 | - | 1,493,000,516.28 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 37,616,695.48 | | 37,616,695.48 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 115,668,000.00 | - | 1,414,949,211.76 | - | 1,530,617,211.76 |
| D01 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D02 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 115,668,000.00 | - | 1,414,949,211.76 | - | 1,530,617,211.76 |
| D03 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D06 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D07 | Тайлант үеийн үр дүн | | | 69,523,403.65 | | 69,523,403.65 |
| D08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 115,668,000.00 | - | 1,484,472,615.41 | - | 1,600,140,615.41 |




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|-------------------------|--------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 922,451,200.00 | 740,466,626.63 | (181,984,573.37) | 80.3% |
| 21 | Урсгал зардлын дүн | 922,451,200.00 | 739,696,656.63 | (182,754,543.37) | 80.2% |
| 210 | Бараа үйлчилгээний зардал | 922,451,200.00 | 739,696,656.63 | (182,754,543.37) | 80.2% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 680,183,300.00 | 540,930,903.95 | (139,252,396.05) | 79.5% |
| 210101 | Үндсэн цалин | 501,113,600.00 | 382,695,493.43 | (118,418,106.57) | 76.4% |
| 210102 | Нэмэгдэл | 174,931,900.00 | 143,826,700.52 | (31,105,199.48) | 82.2% |
| 210104 | Урамшуулал | 4,137,800.00 | 14,408,710.00 | 10,270,910.00 | 348.2% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 79,348,100.00 | 68,135,799.45 | (11,212,300.55) | 85.9% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,958,200.00 | 46,551,228.88 | (7,406,971.12) | 86.3% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,346,300.00 | 5,725,017.01 | (621,282.99) | 90.2% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,173,900.00 | 2,885,757.71 | (288,142.29) | 90.9% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,173,900.00 | 2,594,758.94 | (579,141.06) | 81.8% |
| 210205 | ЭМД-ын хураамж | 12,695,800.00 | 10,379,036.91 | (2,316,763.09) | 81.8% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,813,100.00 | 20,493,370.11 | (16,319,729.89) | 55.7% |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,825,400.00 | 6,175,228.11 | (5,650,171.89) | 52.2% |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 12,822,600.00 | 6,291,466.28 | (6,531,133.72) | 49.1% |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 12,165,100.00 | 8,026,675.72 | (4,138,424.28) | 66.0% |
| 2105 | Нормативт зардал | 87,768,000.00 | 77,318,923.00 | (10,449,077.00) | 88.1% |
| 210502 | Хоол хүнс | 87,768,000.00 | 77,318,923.00 | (10,449,077.00) | 88.1% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,500,000.00 | 8,497,650.00 | (2,350.00) | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 8,500,000.00 | 8,497,650.00 | (2,350.00) | 100.0% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 2,863,300.00 | 2,245,000.00 | (618,300.00) | 78.4% |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,863,300.00 | 2,245,000.00 | (618,300.00) | 78.4% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,975,400.00 | 22,075,010.12 | (4,900,389.88) | 81.8% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,857,500.00 | 13,977,560.12 | (4,879,939.88) | 74.1% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,117,900.00 | 8,097,450.00 | (20,450.00) | 99.7% |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 769,970.00 | 769,970.00 | - |
| | Дотоод эх үүсвэрээр | | | - | - |
| | Тоног төхөөрөмж | | 769,970.00 | 769,970.00 | - |
| | Бусад хөрөнгө | | | - | - |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 922,451,200.00 | 808,238,520.11 | (114,212,679.89) | 87.6% |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 779,247,500.00 | 779,247,500.00 | - | 100.0% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 779,247,500.00 | 779,247,500.00 | - | 100.0% |
| | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 97,890,600.00 | 0.00 | (97,890,600.00) | 0.0% |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 45,313,100.00 | 28,991,020.11 | (16,322,079.89) | 64.0% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 45,313,100.00 | 28,991,020.11 | (16,322,079.89) | 64.0% |
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 97,891,648.51 | 97,891,648.51 | |

| | | | | | | |
|---|--|-------|----------------|----------------|--------|------|
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 165,663,541.99 | 165,663,541.99 | | |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | - | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | | - | 100% |
| 3 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | | - | 100% |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 29.00 | 27.00 | | (2.00) | 93% |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | - | 100% |
| | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 19.00 | | (1.00) | 95% |
| | Үйлчлэх ажилтан | 8.00 | 7.00 | | (1.00) | 88% |



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн 29 дүгээр цэцэрлэг нь “Зөв харилцаа хандлагатай, тэгш эрхтэй хамт олныг бүрдүүлж, хүүхдийн эрхийг дээдлэн хүндэтгэж, эрүүл аюулгүй орчинд хүүхдийн сурах үйлийг эрхэмлэж, хөгжил хамгааллын цогц үйлчилгээг хамтын ажиллагаанд суурилан хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 53 дугаар “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол
- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол
- Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам
- Засгийн газрын 2024 оны 237 дугаар “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дугаар “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 дугаар “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,523.4 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 97,891.6 | 165,663.5 | 67,771.9 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 27,479.9 | 34,914.9 | 7,435.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,405,245.7 | 1,399,562.2 | (5,683.4) |
| Нийт хөрөнгө | 1,530,617.2 | 1,600,140.6 | 69,523.4 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,530,617.2 | 1,600,140.6 | 69,523.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,530,617.2 | 1,600,140.6 | 69,523.4 |

Тайлант оны эцэст төвлөрсөн мөнгөнөөс 67,771.9 мянган төгрөг үлдэж, төрийн сангийн харилцах дансанд 165,663.5 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,914.9 мянган төгрөг болж 7,435.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 102,414.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 94,979.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,399,562.2 мянган төгрөг болж 5,683.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 769.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авч, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 13,408.5 мянган

төгрөгийн компьютер, 12,771.4 мянган төгрөгийн угаалгын машин, 5,742.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч, нийт 40,262.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ОНӨГ-ын даргын 2024 оны А/35 тоот тушаалаар 1,320.0 мянган төгрөгөөр программ хангамжийг дахин үнэлж, тайлант онд 48,035.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,600,140.6 мянган төгрөг болж 69,523.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 580,085.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,313.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 625,398.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 779,247.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,000.0 мянган төгрөг буюу нийт 809,247.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 779,247.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,313.1 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 97,890.6 мянган төгрөг, нийт 922,451.2 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 779,247.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас үйл ажиллагаандаа 740,466.6 мянган төгрөгийг зарцуулж, 1,009.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, зарцуулаагүй үлдсэн 67,771.9 мянган төгрөгөөр харилцах данс нэмэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 740,466.6 мянган төгрөг буюу 80.3 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 181,984.6 мянган төгрөгийн зардлыг тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө,

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|---------------------------------------|------------|-----------|------------|---------|
| 1 | 71801-СӨБ | | | | |
| 1.1 | 80111- Тогтмол зардал | 45,313.1 | 30,000.0 | (15,313.1) | 66.2% |
| 1.2 | 80233-Хүүхэд хамгаалал | 1,167.4 | 1,166.9 | (0.5) | 100.0% |
| 1.3 | 81605- Эрүүл мэндийг | 1,818.0 | 917.0 | (901.0) | 50.4% |
| 1.4 | 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 87,768.0 | 77,318.9 | (10,449.1) | 88.1% |
| 1.5 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 2,917.1 | 2,917.0 | - | 100.0% |
| 1.6 | 81823- Боловсролын багшийн сургалт | 1,774.6 | 709.6 | (1,065.0) | 40.0% |

| | | | | | |
|-----|-------------------------------------|------------------|------------------|--------------------|--------------|
| 1.7 | 81834- Боловсролын стандарт сургалт | 778,955.1 | 624,699.3 | (154,255.8) | 80.2% |
| 1.8 | 81835- Сургалтын хэвийн үйл | 2,737.9 | 2,737.9 | - | 100.0% |
| | Нийт дүн | 922,451.2 | 740,466.6 | (181,984.6) | 80.3% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 19 ажилтан, үйлчлэх 7 ажилтан буюу нийт 34 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 13,977.6 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 19,496.1 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 66,313.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа ажил, үйлчилгээний төлбөр тооцоо, зардлын данс болон Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 550,583.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,505.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан,

гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1,263.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| акт | 3 | 1,263.4 | 3 | 1,263.4 | 100 |
| Нийт дүн | 3 | 1,263.4 | 3 | 1,263.4 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 656,219.2 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 123,028.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 73,768.2 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл буурч төсвийн гүйцэтгэл 80.3% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 556.1 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд орлого үр дүнгийн тайланд тайлагнасан цалингийн зардлыг цахим татварын системийн ТТ-11 буюу “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татвар”-ын тайланд 556.1 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” 5.1.4. “үнэн зөв байх” заалт, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул ТТ-1 тайланд бүрэн тайлагнаж залруулав.

Аудитаар нийт 2,316.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

5.3.2.1 Илрүүлэлт: Тайлант онд 2,316.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Тайлангийн 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | |
|--|--------------------|--------------|-----------------------------------|--------------|--------------------------|----------|------------|--------------|----------|----------|
| | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | Залруулаагүй | Тоо | Дүн |
| 2024 оны орлого үр дүнгийн тайланд тайлагнасан цалингийн зардал нь татварын цахим тайланд 556.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 556.1 | 1 | 556.1 | - | - | 1 | 556.1 | - | - |
| Дүн | 1 | 556.1 | 1 | 556.1 | - | - | 1 | 556.1 | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | |
|---|--------------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|----------|--------------------------------------|----------|---|----------|
| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Сарангэрэлийг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. | 1 | 2,316.0 | - | - | 1 | 2,316.0 | - | - | - | - | - | - |
| Дүн | 1 | 2,316.0 | - | - | 1 | 2,316.0 | - | - | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|--|
| | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Тус цэцэрлэгийн Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | | |
| Дүн | 1 | - | - | - | 1 | - | | |